АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 17 өдөр Дугаар А/01 Эрдэнэбулган сум

Цусны донорын эгнээг өргөжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалт, Донорын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6.1.4, 8.1.1, 5 дугаар бүлгийн 21.1, 21.2 дугаар хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “САЙН ДУРЫН АВЛАГАГҮЙ ЦУСНЫ ДОНОРООС-ЦУС ЦУГЛУУЛАХ ҮЙЛ ЯВЦ” сургалтын удирдамжийг нэгдүгээр, цусны донорын эгнээг өргөжүүлэх, цус цуглуулах үйл ажиллагаанд оролцох сум, эмнэлгийн мэргэжилтний хуваарийг хоёрдугаар, цусны донорын тоон мэдээллийн тайлан мэдээ ирүүлэх хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Хуваарийн дагуу цусны донорыг эмнэлгийн мэргэжилтний хамт илгээж, донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаа, яаралтай болон гамшгийн үеийн бэлэн байдалд бүртгэлтэй цусны доноруудыг татан оролцуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж, заасан хугацаанд тайланг ирүүлэхийг сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Цусны донорын эгнээг өргөжүүлэх, аюулгүй цус цуглуулах, сургалт үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахыг Нэгдсэн эмнэлгийн дарга /Т.Ганбямба/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /П.Отгонсүрэн/-д даалгасугай.

ДАРГА Р.ГАНДИЙМАА

651223024

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн
А/01 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

"САЙН ДУРЫН АВЛАГАГҮЙ ЦУСНЫ ДОНОРООС-ЦУС ЦУГЛУУЛАХ ҮЙЛ ЯВЦ "
СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

**Үндэслэл:**

Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй зохистой хэрэглээнд эмчийн үүрэг, эмнэлгийн цус сэлбэх үйл ажиллагааны урсгал дараалал, баримтжуулалт, өвчтөнийг танин тодруулах шинжилгээнд бэлтгэх, сорьц авах, тээвэрлэх, лабораторит хүлээлгэн өгөх, цус цусан бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, өвчтөний орны дэргэдэх цус сэлбэх урсгал дараалал, хяналтын эгзэгтэй цэгийг тодорхойлох, цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал, аюулгүй цус сэлбэлт, цусны бүлэг, резус бүлэг, биологийн тохироо тодорхойлох аргачлалд суралцахад чиглэгдэнэ.

Сумын эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүд **"**Сайн дурын авлагагүй цусны донор**"**-ын тухай сургалт, сурталчилгаа хийж донорын эгнээг өргөжүүлэх, цус цуглуулах үйл ажиллагаанд оролцох мэргэжилтнүүд ЭМС-ын 2017 оны 03, 2018 оны 506, 2020 оны 373 тоот тушаалуудыг уншиж судалж мэдлэгээ бататгах шаардлагатай.

**Зорилго:** Сайн дурын авлагагүй цусны донорын талаар ард иргэдэд үнэн зөв мэдлэг, хандлага, дадлыг сайжруулахад чиглэсэн ярилцлага, видео шторк, постер, нэвтрүүлэг, анимэйшнийг мэдээллэн, сургалт хийж, хуваарьт өдөр бүртгэлтэй доноруудын хамт Архангай Цусны салбар төв дээр ирж цусаа бэлэглэх мөн эмч эмнэлэгийн мэргэжилтэнд ажлын байран дээрхи сургалтыг зохион байгуулахад чиглэгдэнэ.

**Хамрах хүрээ:** Архангай аймгийн 19 сумын эрүүл мэндийн төв, сайн дурын авлагагүй цусны донoруудын хамт

**Хугацаа:** 2023 оны 01 дүгээр сарын 27-оос 2023 оны 11 дүгээр сарын 10-ыг дуустал

**Хамтран зохион байгуулагч:** Эрүүл мэндийн газар, НЭ, Цусны салбар төв

**Хүрэх үр дүн:**

Бусдын эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан өөрийн цусаа сайн дураараа бэлэглэгч цусны донoруудын талаарх мэдээллийг ард иргэдэд үнэн зөв өгч сайн дураараа авлагагүйгээр цусаа бэлэглэх цусны донoруудыг идэвхижүүлэн хамруулсан байна.

Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүд яаралтай үед эрсдэл багатай донор сонгон, цус цуглуулах үйл ажиллагаанд бэлэн байдлыг хангаж, цусаа зөв цуглуулж сурсан байна.

**Тайлан ирүүлэх хугацаа:** 2023 оны 07 дугаар сарын 05, 2024 оны 01 дүгээр сарын 10-ны дотор Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс otgoo@ar.mohs.gov.mn, Цусны салбар төвийн altantsetseg.ebs@gmail.com хаягаар ирүүлэх

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн
А/01 тоот тушаалын 2 дугаар хавсралт

“САЙН ДУРЫН АВЛАГАГҮЙ ЦУСНЫ ДОНОР”-ын тухай сургалт, цус цуглуулах үйл ажиллагаанд оролцох, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн ирэх хуваарь

| № | Сумын нэрс | Доноруудын хамт ирэх өдөр |
|---|---|---|
| 1 | Ихтамир | 2023.01.27 |
| 2 | Батцэнгэл | 2023.02.10 |
| 3 | Булган | 2023.03.03 |
| 4 | Тариат | 2023.03.24 |
| 5 | Чулуут | 2023.04.14 |
| 6 | Хашаат | 2023.04.28 |
| 7 | Хайрхан | 2023.05.19 |
| 8 | Төвшрүүлэх | 2023.06.09 |
| 9 | Жаргалант | 2023.06.23 |
| 10 | Хоршоолол | 2023.07.07 |
| 11 | Цэнхэр | 2023.07.21 |
| 12 | Өгийнуур | 2023.07.28 |
| 13 | Өлзийт | 2023.08.11 |
| 14 | Цэцэрлэг | 2023.08.25 |
| 15 | Хангай | 2023.09.08 |
| 16 | Өндөр-улаан | 2023.09.15 |
| 17 | Эрдэнмандал | 2023.10.13 |
| 18 | Цахир | 2023.10.27 |
| 19 | Хотонт | 2023.11.10 |

Жич: Цусны донор, эмч мэргэжилтний хамт ирэх машин унааны зардлыг эрүүл мэндийн байгууллага хариуцна.

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 1 дүгээр сарын 17 ны өдрийн
А/01 тоот тушаалын 3 дугаар хавсралт

Сумаас тайлан ирүүлэх

| Бүртгэлд байгаа донорын тоо | | | м/д | Нийт |
|---|---|---|---|---|
| А | | | Б | |
| Оны эхэнд бүртгэлд байгаа донорын тоо | | Бүгд | 1 | |
| | | Эмэгтэй | 2 | |
| Үүнээс | Тухайн жилд цусаа бэлэглэсэн донорын тоо | Бүгд | 3 | |
| | | Эмэгтэй | 4 | |
| Тухайн жилд нэмэгдсэн донорын тоо | | Бүгд | 5 | |
| | | Эмэгтэй | 6 | |
| Үүнээс | Шинэ донорын тоо | Бүгд | 7 | |
| | | Эмэгтэй | 8 | |
| | Байнгын донор | Бүгд | 9 | |
| Тухайн жилд үзлэг, асуумж, шинжилгээгээр хасагдсан донорын тоо | | Бүгд | 11 | |
| | | Эмэгтэй | 12 | |
| **Оны эцэст бүртгэлд байгаа донорын тоо** | | **Бүгд** | 13 | |
| | | **Эмэгтэй** | 14 | |

**Мөрийн дагуу: 13=1+5-11, 14=2+2-12**

Донортой холбоотой мэдээлэл

| Аймаг,сумдын нэр | **Бүртгэлд байгаа цусны донорын тоо** | | | | | **Цус өгөлт цус цуглуулсан хэлбэр, насны ангиллаар** | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Донорын төрөл | | м/д | **Сайн дурын авлагагүй** | | | | | **Дүн** |
| | О | А | В | АВ | **Бүгд** | | | | 18 хүртэлх | 18-24 | 25-34 | 35-44 | 45+ | |
| А | 1 | 2 | 3 | 4 | **5** | А | | Б | | | | | | |
| | | | | | | Шинэ донор | Бүгд | 1 | | | | | | |
| | | | | | | | Эмэгтэй | 2 | | | | | | |
| | | | | | | Төрөл төрөгсөдийн донор | Бүгд | 3 | | | | | | |
| | | | | | | | Эмэгтэй | 4 | | | | | | |
| | | | | | | Байнгын донор | Бүгд | 5 | | | | | | |
| | | | | | | | Эмэгтэй | 6 | | | | | | |
| | | | | | | Ауто донор | Бүгд | 7 | | | | | | |
| | | | | | | | Эмэгтэй | 8 | | | | | | |
| **Сумдын дүн** | | | | | | **Нийт** | | **9** | | | | | | |
| | | | | | | **Эмэгтэй** | | **10** | | | | | | |

**Баганын дагуу: 5=1+2+3+4, 6=1+2+3+4+5**
**Мөрийн дагуу: 9=1+3+5+7, 10=2+4+6+8**